



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А-29

Улаанбаатар хот

Зохицуулах зөвлөл байгуулах тухай

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1.1, “Ойн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1., Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар зарлигийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий “Зохицуулах зөвлөл”-ийг байгуулан, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, салбар дундын зохицуулалт хийсэн ажлын тайланг улирал бүрийн эхний 10 хоногт багтаан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдад тайлагнаж байхыг “Зохицуулах зөвлөл”-ийн дарга Н.Дашзэвэгт үүрэг болгосугай.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

000141

Байгаль орчин, ногоон хөгжил,
аялал жуулчлалын сайдын
2015 оны 01 дугаар сарын 05-ны
өдрийн А-2 тоот тушаалын
хавсралт

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	Н.Дашзэвэг	Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх дэд хорооны дарга
Нарийн бичгийн дарга	И.Дорж	Ойн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн
Гишүүд	Ц.Банзрагч	Ойн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	С.Балжинням	Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга
	Б.Алимаа	Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газрын дарга
	Д.Батмөнх	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга
	Ч.Нямдаваа	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагч
	Ц.Ариунбуудай	Цагдаагийн ерөнхий газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын дэд дарга
	Х.Буянтүмэн	Цагдаагийн ерөнхий газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Байгаль хамгаалах, журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга
	Т.Батэрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч
	Г.Болормаа	Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын дарга
	Ш.Цолмонбаяр	Монголын байгаль орчны иргэний зөвлөл

Ойн бодлого зохицуулалтын газар